

УЛААНБААТАР ХОТЫН НАЛАЙХ ДҮҮРГИЙН 6-Р ХОРООНЫ НУТАГ
ДЭВСГЭРТ ГОРХИ-ТЭРЭЛЖИЙН БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ
ГАЗАРТ ХЭРЭГЖИЖ БУЙ “ТАРЬДЫН ШИЛТГЭЭН” ХХК-ИЙН
“АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БААЗ” ТӨСЛИЙН 2025 ОНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

УЛААНБААТАР
2025

ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
1.1. Төслийн нэр.....	3
1.2. Төсөл хэрэгжүүлэгч.....	3
1.3. Төсөл хэрэгжих талбайн байршил.....	3
3.1 Төслийн хүчин чадал, барилга байгууламжийн төлөвлөлт	4
3.1.1 “Б” талбайн хүчин чадал	4
3.1.2 “А” талбайн хүчин чадал.....	5
1.4. Төслийн талбайн дэд бүтцийн хөгжил.....	6
2. БАЙГАЛЬ ОРЧНЫ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ.....	7
4.1 Төслийн болзошгүй нөлөөллийг тодорхойлох.....	7
4.1.1 Магадлан жагсаах аргаар нөлөөлөл тодорхойлсон үр дүн.....	7
3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛГО	13
7.1 Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	13
7.2 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө.....	14
7.3 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	14
7.4 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	14
7.5 Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	14
7.6 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	14
4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	16
5. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	18
6. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	19
7. УДИРДЛАГА-ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	20
8. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	21
9. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	22
10. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	23
11. ДҮГНЭЛТ.....	24

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчмийн магадлан жагсаалт	9
---	---

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн байршил.....	3
Зураг 2. Төслийн талбайн байрзүйн зураг	4
Зураг 3. Барилга байгууламжийн ерөнхий төлөвлөлт	4
Зураг 4. Амрагчдын сууц	5
Зураг 5. Амрагчдын сууцны дотоод орчин.....	5
Зураг 6. Ресторан, гал тогоо	5
Зураг 7. А талбайн төлөвлөлт	6
Зураг 8. Төслийн нөлөөллийн бүс	7

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн нэр

“Аялал жуулчлалын бааз” төсөл


1.2. Төсөл хэрэгжүүлэгч

- “Гарьдын шилтгээн” ХХК
- Улсын бүртгэлийн гэрчилгээ: 9011379071
- Тусгай хамгаалалттай газар нутгийн гэрчилгээ: 0233209
- Регистрийн дугаар: 5657695
- Утас: 99997547


1.3. Төсөл хэрэгжих талбайн байршил

Налайх дүүргийн 6-р хорооны нутаг дэвсгэрт Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын Чингис уулын баруун хойно 4.2 га газарт хэрэгжинэ. “Гарьдын шилтгээн” ХХК нь талбайгаа нэгтгэх, өргөжүүлэхээр Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолбор газрын хамгаалалтын захиргаанд хүсэлт гаргасны дагуу тус хамгаалалтын захиргаанаас уг төслийг хэрэгжүүлэхийг дэмжих саналыг БОАЖЯ-ны ТХГНУГ-т 2019.04.23-ны өдрийн 19/169 тоот албан бичгээр хүргүүлсэн байна.

Төслийн талбай нь “А” (1 га), “Б” (3.2 га) 2 хэсгээс бүрдэх бөгөөд нийт 4.2 га талбайд хэрэгжинэ. Төслийн талбайн байршлыг зураг 2-т харуулав. Төслийн А талбайд одоогоор үйл ажиллагаа явагдаагүй ба Б талбайд идэвхтэй үйл ажиллагаа явагдаж байна.



Зураг 1. Төслийн талбайн байршил



Зураг 2. Төслийн талбайн байрзүйн зураг

3.1 Төслийн хүчин чадал, барилга байгууламжийн төлөвлөлт

3.1.1 “Б” талбайн хүчин чадал

Тус аялал жуулчлалын бааз нь гэр 80 хүн хүлээн авах хүчин чадалтай үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд цаашид төслийн хүчин чадлыг нэмэгдүүлж 120 хүн хүлээн авахаар төсөлд тусгасан байна.

1. Зоогийн газар - 1 ш
2. Ажилчдын байр – 2ш
3. Амралтын гэр – 30 ш
4. Амралтын байр – 3 ш
5. Хүүхдийн тоглоомын талбай
6. Сүүдрэвч
7. Гүний худаг – 3 ш
8. Ариун цэврийн байр
9. Автомашины зогсоол
10. Гадна тохижилт



Зураг 3. Барилга байгууламжийн ерөнхий төлөвлөлт



Зураг 4. Амрагчдын сууц



Зураг 5. Амрагчдын сууцны дотоод орчин



Зураг 6. Ресторан, гал тогоо

3.1.2 “А” талбайн хүчин чадал

А талбайд 2 давхар барилга байгууламж барихаар төлөвлөсөн байна.

- Ресторан, гал тогоо
- Кофе шоп
- Амрагчид буудаллах өрөө
- Хүүхдийн тоглоомын талбай
- Автомашины зогсоол зэргээс бүрдэнэ.



Зураг 7. А талбайн төлөвлөлт

1.4. Төслийн талбайн дэд бүтцийн хөгжил

Цахилгаан хангамж: Жуулчны бааз нь 35/0.4кВ-ын 630кВа хүчин чадал бүхий дэд станц цахилгаан хангамжийн зориулалттай барилга байгууламжтай.

Дулаан хангамж: Төсөл нь уурын зуухаар халаагуураар шийдэж байна.

Цэвэр усны хангамж: Төслийн талбай дахь унд ахуйн зориулалт бүхий өөрийн гүний худгаас хангана.

Харилцаа холбоо: Утсан холбоонд үүрэн телефон холбоог ашиглах боломжтой бөгөөд дотоод сүлжээний систем, барилгын автомат хяналтын систем, дохиолол хамгаалалтын систем байна.


Зам харилцаа: Улаанбаатар-Тэрэлжийн хатуу хучилттай замаас 275 орчим метр шороон замаар явж тус жуулчны баазад хүрнэ.

2. БАЙГАЛЬ ОРЧНЫ ГОЛ БОЛОН БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Нөлөөллийн үнэлгээний энэ үе шатанд хэрэгжүүлж буй “Аялал жуулчлалын бааз” төслийг хэрэгжүүлснээр төслийн танилцуулга болон бусад холбогдох бичиг баримтыг нарийвчлан судалж, төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөллийг засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 58 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”-ын дагуу дараах аргачлалд заасан нөлөөллийн эх үүсвэр, тэдгээрт өртөгдөх байгаль, нийгэм, эдийн засгийн хам бүрдлийг тодорхойлох “Магадлан жагсаах” (checklist), болон “Леопольдын матрицын арга”, нөлөөлөл буурах функц ArcGIS 10.3 программын “MDT” түүлс ашиглан тодорхойлов. Дээрх сөрөг нөлөөллийг тодорхойлсны үндсэн дээр үйлдвэрийн технологийн болон үйл ажиллагааны менежментийн хувьд хэрэгжүүлэх боломжтой шийдэл зөвлөмжийг боловсруулсан болно.

4.1 Төслийн болзошгүй нөлөөллийг тодорхойлох

Төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх нөлөөллийн бүсийг урьдчилсан байдлаар тогтоохдоо 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 58 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам” болон нөлөөлөл буурах функц ArcGIS 10.3 программын “MDT” түүлс ашигласан болно. Төслийн орон зайн хамрах хүрээ нь шууд болон шууд бус нөлөөллийн бүсээр тодорхойлогдоно. Тухайн төсөл нь А болон Б талбайгаас бүрдэх ба Б талбайд үйл ажиллагаа идэвхтэй явагдаж байна.



Зураг 8. Төслийн нөлөөллийн бүс

4.1.1 Магадлан жагсаах аргаар нөлөөлөл тодорхойлсон үр дүн

Нөлөөллийн хэлбэр, шууд, шууд бус эсэх, дараалал, буцалттай, буцалтгүй эсэх, хугацаа зэргийг магадлан жагсаах аргыг (checklist) ашиглан тодорхойлов. Р.Мижиддорж нар байгаль орчны үнэлгээнд магадлан жагсаах аргыг ашиглах 2 хувилбарыг нэгтгэсэн байдлаар боловсруулсан байдаг /Р. Мижиддорж, 2002 он/. Үүнд:

А. Экосистемийн бүрэлдэхүүн хэсгүүдэд нөлөөлөх байдал. Энд байгаль экосистемийн өөрчлөлт, байгалийн нөөцийн ашиглалт, орчны чанарын өөрчлөлт,

байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор, эдийн засаг, нийгмийн асуудал, бусад асуудал гэсэн хэсэг бүрт хамаарах нөлөөллийн хэлбэр (шууд, шууд бус), хугацаа (богино болон урт хугацааны), нөлөөллийн эрчим (хүчтэй, дунд зэрэг, бага)-ийг харуулсан магадлах жагсаалтыг нэрлэж болно.

Б. Төслийн байршил, шийдэлтэй холбоотой нөлөөллийн магадлан жагсаалт. Үүнд: Төслийн байршил, уг төслийн шийдэл, төлөвлөгөөтэй холбоотой нөлөөлөл, мөн барилга байгууламж барих, үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагаатай холбоотой байгаль орчны асуудал, төслийг ерөнхийд нь хянаж үзэх шалгуур буюу бодлогын чанартай асуудалд хамаарах үйлдвэр аж ахуйн газрын нөлөөллийн эрчмийг заасан байдаг.

А. Экосистемийн бүрэлдэхүүн хэсгүүдэд нөлөөлөх байдал

Байгаль экосистемийн өөрчлөлт:

Аялал жуулчлалын бааз нь унд ахуйн усны хэрэглээг ашиглалтын талбай дахь гүний худгаас хангадаг тул газрын доорх усны нөөцөд шууд нөлөөлөх бөгөөд харин гадаргын усны нөөцөд үзүүлэх нөлөөлөл нь шууд бус шинжтэй байна. Аялал жуулчлалын цогцолборын үйл ажиллагаагаар хүн, машин техникийн хөдөлгөөн ихсэх зэргээс эдэлбэр газар болон түүний ойролцоох хөрс, ургамалд шууд нөлөөлнө. Энэ нь зам талбайн тэмдэг тэмдэгжүүлэлт хангалтгүй, тээврийн хэрэгсэл тогтсон нэг замаар зорчоогүй зэргээс олон салаа шороон зам үүсч, тухайн орчны өнгөн хөрс дарагдах, элэгдэл, эвдрэлд орох, хүн, машин техникийн нөлөөгөөр ургамлан бүрхэвч талхлагдах зэрэг болно.

Улаанбаатар-Тэрэлжийн хатуу хучилттай зам дагуу байршилтай. Шороон замаас үүсэх шууд нөлөөлөл харьцангуй бага хэдий ч эдэлбэр газрын дотоод талбайн явган хүний болон авто зам, авто машины зогсоол зэргийг зөв зохион байгуулж төлөвлөөгүйн улмаас үүсэх сөрөг нөлөөлөл нь хөрс, ургамалан орчноос гадна агаарт тоос, тоосонцрыг үүсгэж болзошгүй. Иймд цогцолборын эдэлбэр газар болон түүний ойр орчимд нь хөрс, ургамлыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг байнга авч байх, шороон замыг сайжруулах, автомашины зогсоолыг хатуу эсвэл хайрган хучилттай болгох, авто тээврийн хэрэгслийг тогтсон нэг замаар зорчуулах, тэмдэг тэмдэгжүүлэлтийг стандартын дагуу байршуулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэх нь зүйтэй.

Мөн тус аялал жуулчлалын цогцолбор болон тухайн орчинд хэрэгжиж буй бусад төсөл, амрагч жуулчид, дайран өнгөрөх хүн, машин техникийн нөлөөллөөс амьтдын орон зайн өөрчлөлт гарах магадлал бий.

Байгалийн баялаг, нөөц ашиглалт:

Аялал жуулчлалын цогцолбор нь үйлчилгээний салбарт хамаарагдаж, амралт, аяллын үндсэн үйл ажиллагаа эрхлэх бөгөөд олборлох болон уул, газар шорооны ямар нэгэн ажил, үйлдвэрлэл эрхлэхгүй тул байгалийн нөөц, баялагт шууд хүчтэй нөлөөлөлгүй.

Гэр, жижиг хэмжээний барилга, байгууламж зэргийг барихад хөрс тэр хэмжээгээр дарагдана. Төсөл хэрэгжих явцад унд ахуйн усны хэрэглээг өөрийн эзэмшил талбайд гаргуулах гүний худгаас хангах бөгөөд байгалийн нөөцөд шууд байдлаар нөлөөлж буй тул үл нөхөн сэргээгдэх /маш удаан/ байгалийн баялгийг үр ашигтай, хэмнэлттэй ашиглах нь зүйтэй.

Төслийн эдэлбэр газрын хэмжээтэй тэнцэх бэлчээрийн талбай төдий хэмжээнд багасна. Тухайн цогцолборын ашиглалтын газар болон ойр орчимд нь хөрс, ургамал хамгаалах нөхөн сэргээх талаар шат дараалсан, бодитой арга хэмжээ аваагүй нөхцөлд ургамлын төрөл зүйлд өөрчлөлт орж байгалийн унаган төрхөө алдах, цаашлаад устах аюултай.

Байгаль орчны чанарын өөрчлөлт:

Бохир ус хуримтлуулах септик, дамжуулах шугам хоолойд гэмтэл гарах, хатуу хог хаягдлыг удаан хугацааны турш хадгалснаас болж эвгүй үнэр гарах, хүчин чадлаасаа давсан үйл ажиллагаа явуулж хүн, тээврийн хэрэгслийн хөл хөдөлгөөн ихсэх, дуу чимээ ихсэх, орчны цэвэрлэгээ байнга хийгээгүй зэргээс агаар, хөрс, усан орчин бохирдох бөгөөд үүний улмаас ургамлын төрөл зүйл өөрчлөгдөх ан, амьтан үргэн дайжих гэх мэт сөрөг нөлөөлөл гарч болзошгүй.

Аялал жуулчлалын цогцолборын олон жилийн ашиглалт, байгаль орчны хуримтлагдах нөлөөллийн улмаас хөрсний бохирдол үүсэх, ургамлан нөмрөг талхлагдах, цаашлаад байгалийн сэргэлт, нөхөн төлжилт, өөрөө өөрийгөө цэвэрлэх чадамж буурах магадлалтай.

Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, тусгай хамгаалалттай газар нутаг, археологи, палеонтологийн олдвор:

Аялал жуулчлалын цогцолбор нь Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүсэд байрлана. Амрагч жуулчид, ажилчдад байгаль хамгаалах, тусгай хамгаалалттай газар нутгийн талаар танилцуулга сурталчилгаа хийгээгүй, анхааруулах самбар, тэмдэг хангалтгүй нөхцөлд төсөл хэрэгжиж буй Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын байгалийн унаган төрх нь алдагдах, ургамлын төрөл зүйлд бага зэргийн өөрчлөлт орох гэх мэт бага эрчимтэй сөрөг нөлөө үзүүлэх бөгөөд энэ нь шууд нөлөөлөлд хамаарна. Цогцолборын үйл ажиллагаанаас түүх соёлын дурсгалт зүйл археологи, палеонтологийн олдвор зэрэгт ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй болно.

Эдийн засаг, нийгмийн асуудал:

Төсөл хэрэгжсэнээр төсвийн орлого, ажлын байр нэмэгдэж ядуурлыг бууруулах, дэд бүтцийг хөгжүүлэхэд түлхэц болсноор эдийн засаг-нийгмийн хувьд урт хугацааны, шууд эерэг нөлөө үзүүлнэ. Мөн тухайн орчны малчдын морь мал, сүү цагаан идээ, гар урлалын бүтээгдэхүүн зэрэг нь эдийн засгийн эргэлтэнд ороход дэмжлэг болох боломжтой.

Бусад нөлөөлөл:

Аялал жуулчлалын цогцолбор нь гадаргын устай ойр орших тул бохирын цооног халих, амрагчид голын захаар хог хаягдал хаях, орчныг бохирдуулах зэрэг гадаргын урсацад сөргөөр нөлөөлөх нөхцөлтэй. Иймд шингэн хаягдлыг хальж гадагш асгарахгүй байх арга хэмжээг тогтмол авч байх, амрагчдад хүрээлэн буй орчноо бохирдуулахгүй байх талаар зөвлөмж өгөх, хатуу хаягдлыг ангилан ялгаж хийх зориулалт бүхий хогийн сав хүрэлцээтэй байршуулах нь зүйтэй.

Төслийн үйл ажиллагаа болон дэд бүтцэд байгалийн онцгой аюул (үер, салхи, газар хөдлөл, шавжийн нүүдэл аянга, түймэр г.м) нөлөөлөл нь байгаль орчинд асар их хэмжээний хохирол учруулахаас гадна нийгэм, эдийн засгийн хувьд ч хүчтэй сөрөг нөлөө үзүүлнэ. Энэ нь буцаж нөлөөлөх бөгөөд шууд нөлөөлөлд хамаарна.

Хүснэгт 1. Байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчмийн магадлан жагсаалт

№	Байгаль орчны үзүүлэлт	Нөлөөллийн хэлбэр			Үргэлжлэх хугацаа		Нөлөөллийн чиглэл		Нөлөөллийн эрчим		
		Шууд	Шууд бус	Өөрөө	Богино хугацааны	Урт хугацааны	Буцалттай нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
Байгаль экосистемийн өөрчлөлт											

1	Газрын доорх усны нөөц хомсдох	x				x		x			x
2	Гадаргын усны урсац өөрчлөгдөх										
3	Ургамлын нөмрөг өөрчлөгдөх	x			x		x			x	
4	Хөрсний элэгдэл, эвдрэл	x				x	x			x	
5	Геологийн тогтоц өөрчлөгдөх										
6	Геоморфологийн нөхцөлд өөрчлөлт орох										
7	Амьтдын орон зайн өөрчлөлт гарах	x			x		x				x
8	Уур амьсгалын (бичил) өөрчлөлт			x		x		x			x
Байгалийн баялаг, нөөц ашиглалт											
1	Ашигт малтмалын нөөц баялаг хомсдох										
2	Эрдэс, түүхий эдийн нөөц хомсдох		x			x		x			x
3	Бэлчээрийн талбай хомсдох	x				x	x				x
4	Ургамлын нөөцөд нөлөөлөх	x				x	x				x
5	Ойн нөөцөд нөлөөлөх	x				x	x				x
6	Ус намгархаг газарт нөлөөлөх										
7	Биологийн олон янз байдалд нөлөөлөх	x				x	x				x
8	Эрчим хүчний нөөц	x				x	x				x
Байгаль орчны чанарын өөрчлөлт											
1	Газрын доорх усны чанар		x			x		x			x
2	Гадаргын усны чанар										
3	Агаарын бохирдлын бага зэргийн тухайлсан эх үүсвэр бий болох	x			x		x				x
4	Хөрсний бохирдол	x				x	x				x
5	Дуу чимээ, шуугианы нөлөөлөл	x			x		x				x
Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор											
1	Байгалийн унаган төрх өөрчлөгдөх	x				x		x			x
2	Ландшафтын хэлбэр өөрчлөгдөх	x				x		x			x
3	Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх	x				x	x			x	
4	Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх										
5	Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх										
Эдийн засаг, нийгмийн асуудал											
1	Орон нутгийн төсвийн орлого нэмэгдэх	+				+	+				+
2	Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох		+			+	+				+
3	Ажлын байр нэмэгдэх	+				+	+				+
4	Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	+			+		+				+
5	Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх	+				+	+				+
6	Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх	+				+	+				+
Бусад нөлөөлөл											
1	Химийн бодисын нөлөөлөл										

2	Ахуйн хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавж үржих /Үнэрийн бохирдол/	x			x		x				x
3	Төслийн үйл ажиллагаа, хүчтэй салхи шуурга, түймэр, газар хөдлөлт, аянга зэрэг байгалийн гамшгаас үүдэн аюул, осол гарах	x			x		x		x		
Дүн = 35		17/5	2/1	1	6/1	14/5	14/6	6	1	3	16/6
Хувь = 100%		62.9	8.6	2.9	30.0	54.2	57.1	17.1	2.9	8.6	62.9

Тайлбар: x - сөрөг нөлөөлөл

+ - эерэг нөлөөлөл

Хүснэгтээс үзвэл байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийн нийт тоо 35 байна.

Эдгээрийг тодруулж авч үзвэл:

Нөлөөллийн хэлбэр

Шууд нөлөөлөл – Аялал жуулчлалын цогцолборын үйл ажиллагаанаас үүдэн гарч болзошгүй шууд нөлөөлөл 22 /62.9%/ байна. Шууд нөлөөллөөс 17 /77.3%/ нөлөөлөл сөрөг, 5 /22.7%/ нөлөөлөл эерэгээр нөлөөлнө. Төслийн үйл ажиллагааны явцад газрын доорх ус, ургамлан нөмрөг, хөрс, агаар, амьтан зэрэгт шууд сөргөөр нөлөөлөх талтай бол орон нутгийн нийгэм, эдийн засагт шууд эерэгээр нөлөөлөхөөр байна.

Шууд бус нөлөөлөл - Үүнд 3 /8.6%/ төрлийн нөлөөлөл багтаж байна. Шууд бус нөлөөллөөс 2 /66.7%/ сөрөг, 1 /33.3%/ нөлөөлөл эерэгээр нөлөөлнө. Үүнд, эрдэс, түүхий эдийн нөөц хомсдох, газрын доорх усны чанар өөрчлөгдөх зэрэг нь шууд бус сөрөг нөлөөллүүд бол төсөл хэрэгжсэнээр ядуурлыг бууруулахад шууд бус эерэг нөлөө гарна.

Нөлөөллийн үргэлжлэх хугацаа

Болзошгүй нөлөөллийг үргэлжлэх хугацаагаар нь авч үзвэл богино хугацааны нөлөөлөл 7 /30.0%/, урт хугацааны нөлөөлөл 19 /54.2%/ байна. Нөлөөллийн ихэнх нь урт хугацааны нөлөөлөл байгаа нь төслийн хэрэгжүүлэх хугацаанд сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төлөвлөгөөний дагуу байнга тасралтгүй хийж байх шаардлагатайг харуулж байна.

Нөлөөллийн чиглэл

Энэ хүрээнд нийт болзошгүй нөлөөллийг “буцалттай нөлөөлөл” болон “буцалтгүй нөлөөлөл” гэж 2 хэсэгт хувааж үзэв. Аялал жуулчлалын цогцолборын үйл ажиллагаанаас 20 /57.1%/ нөлөөлөл буцалттай буюу үр дагавар нь ирээдүйд арилах боломжтой нөлөөлөл байна. Нөгөө талаар энэ нь төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлж буй нөлөөллүүд байгалийн нөхөн сэргэх боломжид сөрөг нөлөөлөл үзүүлэх нь бага байгааг харуулж байна. Харин нийт нөлөөллийн 6 /17.1%/ нь буцалтгүй нөлөөлөл байгаа буюу тухайн өөрчлөгдсөн зүйлс эргэн хэвэндээ орохгүй чиглэлтэй байна. Байгаль орчинд сөргөөр, буцалтгүй байдлаар нөлөөлөх тохиолдолд түүнд сөрөг нөлөөлөл багатай үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх нь зүйтэй.

Нөлөөллийн эрчим

Төслийн сөрөг нөлөөллийн эрчмийг тодорхойлсон хэсгээс үзэхэд нийт 35 нөлөөллөөс 1 нөлөөлөл хүчтэй, 8.6% буюу 3 нөлөөлөл дунд зэрэг, 62.9% буюу 22 нөлөөлөл бага зэрэг эрчимтэйгээр нөлөөлж байна. Төслөөс нийгэм, эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх бол хүчтэй, дунд зэрэг эрчимтэй, сөрөг нөлөөллүүдийг онцгойлон анхаарч, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах ажлыг хэрэгжүүлснээр сөрөг нөлөөллийн эрчмийг бууруулах, нөлөөлөл багатайгаар үйл ажиллагаа явуулах боломжтой юм.

Б. Төслийн байршил, шийдэлтэй холбоотой болзошгүй нөлөөлөл

Аялал жуулчлалын цогцолборын үйл ажиллагаа, байршил, төслийн технологийн шийдэл болон төсөл хэрэгжих үеийн байгаль орчны асуудлыг авч үзэхдээ магадлан жагсаах аргыг ашиглан түүний нөлөөллийн үр дагаврыг “бага”, “дунд”, “их” гэсэн утгуудын аль тохироход (0) нөлөөлөлгүй, (-) сөрөг нөлөөлөлтэй, (+) эерэг нөлөөлөлтэй гэж тэмдэглэв.

3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛГО

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго:

“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-д зааснаар “Гарьдын шилтгээн” ХХК нь “Аялал жуулчлалын бааз” төслийг хэрэгжүүлэхдээ тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, үнэлгээний тайлангийн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий боолж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллах үүргийг хүлээнэ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгана. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгана.

“Аялал жуулчлалын бааз” төслийг хэрэгжүүлэгч “Гарьдын шилтгээн” ХХК нь тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 12 дугаар сард багтаан БОУАӨЯ-д хүргүүлж дараа оны төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлын хэмжээг батлуулах үүрэгтэй.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласнаар доорх зорилтуудыг хангана. Үүнд:

- Байгаль орчны хууль тогтоомжийн холбогдох зүйл заалт, журам заавар, стандартын шаардлагад нийцүүлэн төслийн үйл ажиллагааг явуулна.
- Байгаль орчны менежментийн асуудлаар БОННУ-ний тайланд боловсруулан тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмжүүдийг хэрэгжүүлнэ.
- Ажилчид байгаль орчны хамгаалах асуудалтай холбоотой үүрэг хариуцлагаа ойлгосон байх, сургалтанд хамрагдах боломжтой болно.
- Байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдэлийг урьдчилсан тооцсоноор байгальд шууд болон шууд бус хэлбэрээр үзүүлэх нөлөөллийг бууруулах, байгаль орчны төлөв байдлыг хадгалж, хамгаална.
- Сум орон нутгийн удирдлага, тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа, хяналтын байгууллага, ард иргэдтэй байгаль хамгаалах асуудлаар зөвлөлдөж, тэдний саналыг авч хамтран ажиллах нөхцөл бүрдэнэ.

7.1 Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө

Тус төлөвлөгөөний гол зорилго нь БОННУ-ний тайлангийн “Бүлэг 6”-д тодорхойлсон гол сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгахад оршино. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө /БОХТ/ нь төлөвлөж буй төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлж буй төслийг хэрэгжүүлэгч “Гарьдын шилтгээн” ХХК-аас заавал хэрэгжүүлж, мөрдөж ажиллах баримт бичиг юм.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хууль, БОУАӨЯ-аас гаргасан ерөнхий үнэлгээний дүгнэлтэд

заасан шаардлагуудтай уялдуулан боловсруулсан ба тэдгээрийн хэрэгжилтийг 5 жилийн хугацаанд буюу 2025 оноос 2029 оны хүртэлх хугацаанд төлөвлөв. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг холбогдох журам, ерөнхий үнэлгээгээр тавигдсан шаардлагын дагуу урьдчилсан байдлаар тодорхойлж тусгав. Эдгээр зардлууд нь байгаль орчныг хамгаалах ажлын шууд зардлууд бөгөөд түүнтэй холбогдон гарах бусад зураг төслийн буюу туслах чанарын ажлуудын зардал ороогүй болно.

БОХТ-ний биелэлтийн үр дүнгийн жил бүрийн тайланг тухайн оны 11.01-ний өдрийн дотор БОУАӨЯ-нд ирүүлж, мөн орон нутгийн засаг захиргааны байгууллага, тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа, нутгийн оршин суугчдад танилцуулж, хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах шаардлагатай.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө: Улаанбаатар хотын Налайх дүүргийн 6-р хорооны нутаг дэвсгэр, Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүсэд “Гарьдын шилтгээн” ХХК-ийн хэрэгжүүлж буй “Аялал жуулчлалын бааз” төслөөс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл “бага” эрчимтэй боловч үйл ажиллагаанаас гарах ахуйн шингэн хаягдал, хатуу хог хаягдлаас үзүүлэх нөлөөлөл, хөрс, ургамал, газрын доорх ус болон бусад хам бүрдэлд үзүүлэх нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх арилгах, бууруулах үүднээс төслийг хэрэгжүүлэхдээ дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

7.2 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө нь газрын тос, уул уурхай, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын үлдэгдэл нөлөөлөлд өртөн нөхөн сэргэхгүй газарт биологийн олон янз байдлыг тухайн газартай экологийн хувьд төстэй нөхцөлд, өөр газарт дүйцүүлэн хамгаалах ажлыг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг гаргадаг ба уг төслийн хувьд дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөг боловсруулах шаардлагагүй болно.

7.3 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Тус төслийн талбай нь Улаанбаатар хот Налайх дүүрэг, Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүсэд байрладаг. Төслийн талбай нь бусад газар ашиглагч нарын зөвшөөрөл бүхий газартай давхцалгүй тул нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ төлөвлөгдөөгүй болно.

7.4 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Тус төслийн талбай орчимд одоогоор түүх, соёлын өв илрээгүй. Тус төслийн үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илэрвэл үйл ажиллагаагаа түр зогсоож энэ тухай сум, дүүргийн засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх ба цаашид Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомжыг мөрдөн ажиллах шаардлагатай.

7.5 Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Энэхүү төлөвлөгөөнд батлагдсан аргачлалын дагуу хийсэн байгалийн аюул, гамшгийн үнэлгээгээр тогтоогдсон учирч болзошгүй байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, шаардагдах зардлыг Удирдлага-зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөнд тусгалаа.

7.6 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

“Гарьдын шилтгээн” ХХК-ийн “Амрагч түр буудаллах, отоглох байр сууц” төсөл нь үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн цар хүрээ, эрчмийг харгалзан үзэж, түүний нөлөөллийн бүсийн талбайг хамруулан байгаль орчны хяналт шинжилгээний мониторингийн системийг байгуулах нь зүйтэй.

Тухайн төслийг хэрэгжүүлснээс үүдэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг “орчны хяналт шинжилгээний хөтөлбөр” /ОХШХ/ гэнэ. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь төслийг хэрэгжүүлэх явцад үүссэн сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах үйл ажиллагаа ямар үр дүнтэй байгааг илтгэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, орон нутгийн захиргаа болон нутгийн оршин суугчдад бодитой мэдээлэл өгөхөд чухал ач холбогдолтой.

Агаар орчин

ОХШХ-т тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх, сорьцын шинжилгээний төрөл хэлбэрийг хөтөлбөрт тусгагдсаны дагуу графикт хугацаанд нь хийлгэж, дүгнэлт гаргуулж байх, шаардлагатай тохиолдолд холбогдох арга хэмжээг авна. Хийн бохирдлын менежмент нь хүний эрүүл мэндийг хамгаалах, амрагч, ажилчид, нутгийн оршин суугчдын ажиллах, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн байх ёстой буюу төлөвлөлтийн холбогдох үндсэн шалгуурууд агаарт хаяж буй бохирдуулагчдад тавигдах ёстой.

Усны чанар

Усны чанарын шинжилгээг төсөл хэрэгжих хугацаанд хийлгэх хяналт шинжилгээг графикт хугацаанд нь шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргуулан, бохирдол илэрсэн тохиолдолд мэргэжлийн байгууллагатай хамтран түүнийг арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Хөрсөн бүрхэвч

Хөрсний бохирдлын түвшинг дотоодын магадлан итгэмжлэгдсэн лабораториор гүйцэтгүүлэх, хяналт шинжилгээний хөтөлбөрт тогтоосон сорьц авах цэгүүд дээр үргэлжлүүлэх, сорьцын шинжилгээний төрөл хэлбэрийг орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсаны дагуу графикт хугацаанд нь хийлгэж дүгнэлт гаргуулж байх.

4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, төг	Нийт зардал (.төг)	Хэрэгжүүлэгч	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Биелэл-тийн шалгуур Баримтлах хууль журам, стандарт, аргачлал
1	2	3	4	5	6	7	8	9	10
Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ									
Тоосжилт үүсэх, хөрсөн бүрхэвч бохирдох, элэгдэх эвдрэх	Шороон замны арчилгаа	Агаарын чанар	-	-	Үйл ажиллагааны зардалд тусгах	“Гарьдын шилтгээн” ХХК	Нэг удаа	Жилд 2 удаа	Агаарын тухай хууль, Агаар, орчны бохирдлыг бууруулах Үндэсний хөтөлбөр MNS ISO 4227:2002 MNS ISO 4226:2000 MNS 4585:2016
	Орчны агаараас сорьц дээж авч, мэргэжлийн байгууллагаар шинжилгээ хийлгэж, түвшинг тодорхойлуулан, заавар зөвлөмж авч ажиллах	Агаарын чанар	2 цэгт	ОХШХ-Т Тусгагдсан					
Дуу чимээ			2 цэгт						
Гадаргын болон газрын доорх ус нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ									
Ус хэрэглээг багасгах	Борооны усыг харимтлуулж ногоон байгууламжийн усалгаанд ашиглах, хурын ус хуримтлуулах байгууламж байгуулах	Усны нөөц хэмнэх	Иж бүрэн	1	1,500,000	“Гарьдын шилтгээн” ХХК	Нэг удаа	Усны тухай хууль	
Ус ашиглалт	Ус хэмнэгч хошууг баазын гал тогоо, ариун цэврийн өрөө гэх мэт хэрэгцээт газруудад ашиглах	Усны нөөц хэмнэх	Иж бүрэн	100.000		“Гарьдын шилтгээн” ХХК	Нэг удаа		
	Ус ашиглуулах дүгнэлт гаргуулах зөвлөмж			-			Жил бүр		
Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ									
Хөрс, ургамлан нөмрөг талхлагдах, хөрсөн бүрхэвч бохирдох	Хатуу хаягдлыг ахуйн гарал үүслээр нь ялган ангилж, хураан хуримтлуулах зориулалтын цэгт хогийн сав байршуулах	Хог хаягдлын менежмент	-			“Гарьдын шилтгээн” ХХК	Тогтмол	“Хог хаягдлын тухай хууль” MNS	
Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах арга хэмжээ									

БОННУ-ний тайлангийн БОМТ-ны хэрэгжилтийн талаар нутгийн иргэдэд тайлагнах	Орол нийтийн оролцоо, хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд	багц	-	-	-	“Гарьдын шилтгээн” ХХК	ИНХ-ын дарга	БОНХЯ-ны сайдын 2014 оны 1-р сарын 06-ны өдрийн А-03 тоот журам
Нийт				1,600,000				

5. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт
Элэгдэл эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээн, ногоон байгууламж бий болгох	Орчны тохижилтыг сайжруулан төслийн талбайд ногоон байгууламж хийх	Улиас	Ширхэг	14	8.000	112.000	Төсөл хэрэгжих хугацаанд	- Байгаль орчин, эвдэрсэн газрын техникийн нөхөн сэргээлт - MNS5914:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт, хамгаалалт.MNS5916:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах, техникийн ерөнхий шаардлага.
		Шар хуайс	Ширхэг	14	6.000	84.000		
		Хайлаас	Ширхэг	14	4.000	56.000		
		Нийт		42		252.000		
Ногоон байгууламж байгуулах зардал		Зүлэг				23.000		
		Хар шороо				100.000		
		Бордоо				28.000		
		Арготехникийн ажиллагаа				300.000		
Нийт дүн 703.000								

6. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, өртөгч	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ (5 жилээр)	Нэгж зардал (.төг)	Нийт зардал (.төг)	Хэрэгжүүлэгч	Хамтран хэрэгжүүлэгч	Биелэлтийн шалгуур	Баримтлах хууль журам, стандарт, аргачлал
Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө									
Төслийн талбайн хөрс, гүний ус, агаар бохирдох	Төслийн талбайд байрлаж буй хатуу хог хаягдлыг түр хураан хадгалах зориулалтын савны битүүмжлэлийг сайжруулан хог хаягдлыг ангилан ялган дэмдэг тэмдэглэгээгээр өнгийн дагуу янзлах	Баазын өрөө, гэрүүдэд	10ш	100.000	800.000	“Гарьдын шилтгээн” ХХК	-	БОМТ	Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2017 оны А/349 “Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэл” “Хог хаягдлын тухай хууль”, Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр, БОАЖ сайдын 2018.11.17 өдрийн А/443 дугаар тушаал Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага
	“Хог хаягдлын гэрээ” байгуулан, гэрээний дагуу хог хаягдлыг төвлөрсөн цэгт зөөж зайлуулах, тээвэрлүүлэх	Төслийн хэмжээнд	Тогтмол	Гэрээнд заасан төлбөрийн хэмжээгээр. Үйл ажиллагааны зардалд тусгагдсан.		“Гарьдын шилтгээн” ХХК	Налайх дүүргийн ТҮК	Гэрээний дагуу зөвшөөрсөн цэгт зөөж зайлуулдаг байх	
	Аялал жуулчлалын улирал дуусах үед эдэлбэр газар, түүний эргэн тойрны хариуцан хамгаалах талбайн цэвэрлэгээг хийх	Төслийн хэмжээнд	Жилд 1-ээс доошгүй удаа	Үйл ажиллагааны зардалд тусгах			-	Хариуцсан хамгаалалтын захиргаанд хүлээлгэн өгөх	
Хатуу хог хаягдлыг ил задгай, зориулалтын бус цэгт хаях	Хог хаягдлын талаар амрагч, ажилчдад мэдээлэл түгээх, танилцуулга хийх	Амрагч, ажилчид	Тогтмол	Үйл ажиллагааны зардалд тусгах			-	-	
Ялаа шавж үржих, өвчин гарах	Хог хаягдлын цэгт ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх, орчныг бохирдуулахаас сэргийлж ойр орчмыг тогтмол цэвэрлэж байх	Хатуу хог хаягдлын цэгт	Тогтмол, /Жилд 2 удаа/	Зардал тусгах шаардлагагүй		-	-		
Удаан задардаг хатуу хог хаягдал үүсэх	Дахин боловсруулагдах хог хаягдлыг хоёрдогч түүхий эд авах байгууллага, нэгжид нийлүүлэх, гэрээ байгуулах	Төслийн хүрээнд	Тухай бүрт нь	Зардал тусгах шаардлагагүй.		Гэрээ байгуулж ажиллах	-		
Нийт	800.000₮								

7. УДИРДЛАГА-ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв, төгрөг	Хэрэгжүүлэх хуваарь, 2025 он	Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
1	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам боловсруулж мөрдөх	-	+	Захирал	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн зөвлөмж, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг дагаж мөрдөх
2	Ажилчдын дунд байгаль хамгаалах талаар сургалт, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулах - Байгаль орчныг хамгаалах - Гал түймрээс урьдчилан сэргийлэх /шаардлагатай үед гал унтраах багаж хэрэгслийг ашиглаж чаддаг байх/ - Хөдөлмөр хамгаалал	100.000	+	Үйлдвэрийн дарга Мэргэжлийн зөвлөх үйлчилгээний компани	Ажилчдад байгаль орчныг хамгаалах мэдлэг олгох, байгаль болон үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүсэн гарах гэнэтийн осол эрслээс сэргийлэх зэрэг мэдлэг олгох зорилгоор сургалт зохион байгуулах. 2023 онд 1 удаа, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах боломжтой.
3	Ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол оруулах.	-	+	Захирал	Ажиллагсдыг мэргэжлийн эмчийн үзлэгт тогтмол харуулж ажиллах
4	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОУАӨЯ болон Нийслэлийн ЗДТГ-т хүргэн өгч байх	-	+	Захирал	-
5	Газар, ус, цахилгаан ашигласны болон бусад төлбөр	Дотоод зардалаар	+	Захирал	“Газрын төлбөрийн тухай хууль”, “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль”-ийг дагаж мөрдөх
6	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг жил бүр боловсруулж батлуулах	-	+	Захирал	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам
7	Төслийн талбай орчмын иргэдийн санал хүсэлтийг харгалзан хорооны иргэдэд тулгамдаж буй асуудлыг шийдэж өгөхөд дэмжиж туслах, нийгмийн хариуцлагын гэрээ байгуулах	-	+	Захирал	
8	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэрэгжүүлэх, хяналт тавьж ажиллах	-	+	Захирал	“Хог хаягдлын тухай хууль” MNS 5344:2003
9	Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхдээ дүүргийн ТҮК-тэй хийсэн гэрээний дагуу зайлуулах	-	+	Захирал	“Хог хаягдлын тухай хууль” MNS 5344:2003
10	Цахилгаан эрчим хүч хэмнэхийг уриалсан зурагт стикер	40.000	+		
140.000					

8. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хэмжих нэгж	Байршил	Хугацаа ба давтамж	Нэгж зардал (.төг)	Нийт зардал (.төг)	Хэрэгжүүлэгч	Хамтран хэрэгжүүлэгч	Баримтлах стандарт
1. АГААРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ									
1.1.	Хорт хийн агууламж: Азотын давхар исэл (NO ₂) Хүхэрлэг хий (SO ₂) Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO ₂), CO, HCN, O ₂ .	мкг/м ³	Хатуу хог хаягдлын цэг болон авто машины зогсоолын ойролцоо 1 цэгт А болон Б талбайд нийт 4 цэг	Жилд 2 удаа (2 болон 7 сард)	50.0	500.0	Төсөл хэрэгжүүлэгч	Мэргэжлийн байгууллага, судлаач	MNS 4585:2016. MNS 3384:1982. MNS 4048:1988. MNS 0017-2-5-11:1988. MNS 5013:2009. MNS 5014:2009. MNS 5002:2000.
1.2.	Агаарын тоос тоосонцор (PM _{2.5} , PM ₁₀)	мкм	Төслийн талбайд орчимд тоосжилт үүсэх эх үүсвэр орчимд 1 цэгт						
1.3	Цацрагийн хэмжилт		Төслийн талбайн үнсний талбайн ойролцоо	Жилд 2 удаа	50.0	100.0	Төсөл хэрэгжүүлэгч	Мэргэжлийн байгууллага, судлаач	
2. УСНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ									
2.1.	Усны химийн шинжилгээ Био идэвхит нэгдлүүд Нян судлалын үзүүлэлт: Нянгийн тоо Гэдэсний бүлгийн савханцар Эмгэг төрөгч бактери Cl.perferringens	мг/дм ³	Гүний худгаас	Жилд 1 удаа	46.0	46.0	Төсөл хэрэгжүүлэгч	Газарзүй, Гео-экологийн хүрээлэнгийн усны лаборатори, УЦУОШГ, Магадлан итгэмжлэгдсэн лабораториуд	MNS (ISO) 5667-1:2002 MNS (ISO) 5667-2:2002: MNS 4867-1999: УСТ-3534-1983 MNS 0900:2005 MNS 4685:1998
		1 мл-т илрүүлэх 100 мл-т							
3. ХӨРСНИЙ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ									
3.1.	Хөрсний физик, агрохимийн үндсэн үзүүлэлтүүд: Хөрсний морфологи бичиглэл, рН, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент (NO ₃ , P ₂ O ₅ , K ₂ O)	мг	Ногоон байгууламжийн ойролцоо 1 цэгт А болон Б талбай нийт 4 цэгт	Жилд 1 удаа	22.0	110.0	Төсөл хэрэгжүүлэгч	Газарзүй, Гео-экологийн хүрээлэнгийн Хөрс судлалын лаборатори, Магадлан итгэмжлэгдсэн хөрсний лабораториуд	MNS 3298:1991. MNS 5850:2008. MNS 3985-87. MNS 3310-91. MNS 2305-94. MNS 2305:1994.
3.2.	Хөрсний хүнд элементүүд /Pb, Cr, Cd, Ni, Co/		Хатуу хог хаягдлын цэг эсвэл авто зогсоолын ойролцоо	Жилд 2 удаа	26.0	52.0	Төсөл хэрэгжүүлэгч		
1 жилийн ОХШХ-ийн нийт зардал						808.0000			

9. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах арга хэмжээ							
БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар	Хэрэгжүүлэгч	“БОНХЯ-ны сайдын 2014 оны 1-р сарын 06-ны өдрийн А-03 тоот журам” Олон нийтийн оролцоо, хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд
Дүүргийн байгаль орчны газар	Шинжээчдийн дүгнэлтээр баталгаажна.	Тухайн жилийн БОМТ-ний биелэлтийн тайлан	Жил бүрийн 11-р сарын 1-ний дотор	Шинжээчдийн дүгнэлт	Дүүргийн байгаль орчны газар	“Тарьдын шилтгээн” ХХК	
Бүх шатны Засаг дарга, Байгаль орчны улсын байцаагч, орон нутгийн байцаагч	Хуралд танилцуулах, Уулзалт	БОМТ-ийн тухайн жилийн тайлан, Ирэх оны төлөвлөгөө	12-р сарын 1-ний дотор	БОХ арга хэмжээний тайлан, ирэх оны төлөвлөгөөг танилцуулах, санал авах, хамтран ажиллах	Дүүрэг, хороо		
Төрийн бус байгууллагууд, олон нийт			Жил бүр 1 удаа		Тухайн үед сонгох		
Төрийн захиргааны төв байгууллага	Тайлан, төлөвлөгөөг цаасан хэлбэрээр			12-р сарын 10-ний дотор	Хянуулах батлуулах		

10. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах арга хэмжээ						
БОМТ хэрэгжилтийг тайлагнах, оролцох талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Тайлагнах зардал	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
БОУАӨЯ, ХБОВХГ	Тайлан, төлөвлөгөөг цаасан хэлбэрээр	БОМТ-ийн тухайн жилийн тайлан	Жил бүр 1 удаа	-	-	“Гарьдын шилтгээн” ХХК
БОУАӨЯ, ХБОВХГ	Тайлан, төлөвлөгөөг цаасан хэлбэрээр	БОМТ-ийн тухайн жилийн тайлан	Тухайн жилийн 11-12 сарын дотор	-	-	

Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөний 2025 оны зардлыг дараах хүснэгтэд харуулав.

Зардлын хэлбэр	Нийт зардал, төг
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний зардал	1.600.000
Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	703.000
Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал	800.000
Осол, эрсдлийн төлөвлөгөөний зардал	-
Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ	140.000
БОМТ-г хэлэлцүүлэх, тайлагнах зардал	-
Орчны хяналт шинжилгээний зардал	808.000
Нийт	4.4051.000

Гарьдын шилтгээн” ХХК-ийн “Аялал жуулчлалын бааз” төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал 4.451.000 (Дөрвөн сая тавин нэгэн мянга) төгрөг болж байна.

11. ДҮГНЭЛТ

“Гарьдын шилтгээн” ХХК-ийн “Аялал жуулчлалын бааз” төсөл Налайх дүүргийн 6-р хорооны нутаг дэвсгэрт Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт хэрэгжинэ. Төслийг хэрэгжүүлэн үйл ажиллагаагаа явуулж буй “Гарьдын шилтгээн” ХХК нь тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ. 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал **4.451.000** төгрөг зарцуулагдах урьдчилсан дүн гарсан байна.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн бичиг баримт юм.

Төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг 11 дүгээр сарын 01-ний дотор төсөл хэрэгжүүлж байгаа БОУАӨЯ, аймаг, нийслэлийн байгаль орчны газарт хүргүүлэх шаардлагатай.